Golomt Capital®

# Хөрөнгийн зах зээлийн тойм

*Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв* *2022.03.28*

*Олон улсын хөрөнгийн зах зээл*

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## Онцлох индексүүдийн өөрчлөлт

Дэлхийн томоохон индексүүдийг бүс нутгаар нь ангилан долоо хоног, сар, жилийн ханшийн өөрчлөлтийг үзүүлэв. Үүнд, АНУ-ын Dow Jones, S&P500, Nasdaq, ХБНГУ-ын Dax, Английн FTSE 100, БНХАУ-ын CSI 300, Хонгконгийн Hang Seng, Японы Nikkei 225 индексүүд багтана.

| Америкийн индекс | Одоогийн ханш | Долоо хоногийн өмнөх | Өөрчлөлт | Сарын өмнөх | Өөрчлөлт | Жилийн өмнөх | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Dow Jones | $34,861.24 | $34,707.96 | 0.44% | $33,674.84 | 3.52% | $33,072.88 | 5.41% |
| S&P 500 | $4,543.06 | $4,475.17 | 1.52% | $4,348.89 | 4.46% | $3,974.54 | 14.30% |
| Nasdaq | $14,169.30 | $13,919.03 | 1.80% | $13,656.68 | 3.75% | $13,138.73 | 7.84% |

| Европийн индекс | Одоогийн ханш | Долоо хоногийн өмнөх | Өөрчлөлт | Сарын өмнөх | Өөрчлөлт | Жилийн өмнөх | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Dax | € 14,305.76 | € 14,378.34 | -0.50% | € 14,211.84 | 0.66% | € 14,621.36 | -2.16% |
| FTSE 100 | £7,483.35 | £7,419.85 | 0.86% | £7,375.22 | 1.47% | £6,736.20 | 11.09% |

| Азийн индекс | Одоогийн ханш | Долоо хоногийн өмнөх | Өөрчлөлт | Сарын өмнөх | Өөрчлөлт | Жилийн өмнөх | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| CSI 300 | ¥4,174.57 | ¥4,262.12 | -2.05% | ¥4,544.42 | -8.14% | ¥4,926.35 | -15.26% |
| Hang Seng | HKD 21,404.88 | HKD 21,410.75 | -0.03% | HKD 22,576.44 | -5.19% | HKD 27,899.61 | -23.28% |
| Nikkei 225 | JPY 28,149.84 | JPY 26,729.88 | 5.31% | JPY 26,320.28 | 6.95% | JPY 28,729.88 | -2.02% |




**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## Ерөнхийлөгч Жо Байден тэрбумтнуудын татварын доод хэмжээг 20 хувиар шинэчлэн тогтоох санал дэвшүүлэв

Ерөнхийлөгч Жое Байден АНУ-ын 2023 оны төсвийн төсөлд тусгагдсан тэрбумтнуудад ногдуулах татварын шинэ доод хэмжээг танилцуулсан байна.

"Тэрбумтаны орлогын доод татвар" гэж нэрлэгддэг энэхүү татварын төсөлд 100 сая ам.доллараас дээш орлоготой АНУ-ын өрхүүдэд ногдуулах татварын доод хэмжээг 20 хувь болгохоор тусгасан байна. Ингэснээр 1 тэрбум ам.доллараас дээш хөрөнгөтэй өрхийн талаас илүү хувь нь хамрагдахаар байна.

Гэхдээ одоо орлогынхоо 20 хувийг төлж байгаа бол нэмэлт татвар төлөхгүй. Харин 20 хувиас бага татвар төлж байгаа бол "нэмэлт төлбөр" төлөх ёстой юм.

Жое Байдены санал болгож буй энэхүү татварын хэмжээ нь ойрын арван жилд АНУ-ын төсвийн алдагдлыг 360 тэрбум ам.доллараар бууруулахаар байна.

Энэхүү татварын шинэ саналыг конгресс энэ даваа гарагт хэлэлцэх бөгөөд батлагдах эсэх нь тодорхойгүй байна.

## Европын Холбоо болон АНУ мэдээлэл солилцох шинэ гэрээ байгуулахыг зөвшөөрлөө

Европын холбооны дээд шүүхээс АНУ-д төвтэй Мета болон Google зэрэг технологийн томоохон компаниудад хувь хүний нууцлалыг хамгаалах үүднээс иргэдийн мэдээлэл дамжуулахыг 2020 оны 7 сард хориглож байсан.

Тэгвэл өнгөрсөн баасан гарагт Европын холбооноос АНУ-д мэдээлэл дамжуулах “Нууцлалын хамгаалалтын бамбай” хэмээн нэрлэгддэг тохиролцоог сэргээхээр зарчмын хувьд тохирсон байна.

Ерөнхийлөгч Жое Байден "Энэ хэлэлцээр нь хувь хүний нууцлал, мэдээллийг хамгаалах, хууль дээдлэх бидний хамтын амлалтын баталгаа юм” гэж мэдэгджээ. Мөн энэхүү гэрээ нь Европын холбооны эдийн засагт 7.1 их наяд ам.долларын хөрөнгө оруулалт авчрах болно" гэсэн байна.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Харин Европын Холбооны тэргүүн Урсула Фон Дер Лейен “Шинэ гэрээ нь Европын Холбоо болон АНУ-ын хооронд урьдчилан таамаглах боломжтой, найдвартай мэдээллийн урсгалыг идэвхжүүлж, хувь хүний нууц, эрх чөлөөг хамгаална" гэж онцолжээ.

Мета компаниас мэдэгдэхдээ “Энэхүү хэлэлцээр нь мэдээллийн хурд, аюулгүй ажиллагааг хангадаг Америк, Европын технологийн компаниудад үнэлж баршгүй ач холбогдолтой юм" гэжээ.

## ОХУ барууны орнуудын хориг арга хэмжээний эсрэг газрын тос, шатахуунаа крипто валютаар худалдана гэв

Барууны орнууд ОХУ-ын эсрэг хориг арга хэмжээгээ нэмэгдүүлсэн тохиолдолд тус улс газрын тосоо Bitcoin-оор арилжаалж эхлэх магадлалтай байна.

Харин БНХАУ, Турк гэх мэт ОХУ-ын үйл ажиллагааг ээлтэйгээр хүлээн авч буй улс орнуудад төлбөр тооцооны уян хатан нөхцөл үйлчлэх нь ээ.

Бусад дайсагнасан улс орнуудын хувьд Оросын мөнгөн тэмдэгт болох рубль эсвэл алтаар төлөх шаардлагатай хэмээн ОХУ-аас мэдэгдсэн юм.

Энэ мэдээний дараа bitcoin-ы ханш ойролцоогоор 4 хувиар өсөж, 44,000 ам.долларт хүрээд байна.

Шатахууны ханш өсөж буй энэ үед энэхүү мэдэгдэл нь эрчим хүчний салбарт хүнд цохилт үзүүлж байна.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд




### Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд




**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.